



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 14

Хэрлэн сум

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн
Баянхутаг сумын нийгмийн даатгалын байцаагчийн
сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6, 5.7, 3.5, 3.5.4, 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.2, 7.3, 7.4, 7.6, 7.7-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /93/ авсан Оюуны Лувсанчүлтэмийг Нийгмийн даатгалын хэлтсийн Баянхутаг сумын нийгмийн даатгалын байцаагчийн сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч О.Лувсанчүлтэмийг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг ажлын 14 өдрийн дотор албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Нийгмийн даатгалын хэлтсийн дарга /Н.Нямхатан/-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг Нийгмийн даатгалын хэлтсийн даргад хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Эрдэнэжаргал/-д даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР